

Түүх 10 : Талантны сургаалт зүйрлэл

Библийн эшлэл
[Матай 25:21]

Эзэн нь түүнд "Сайн байна, сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор" гэжээ.

Эрт дээр үед нэгэн хүн алс холын улс руу аялахаар шийджээ. Явахаасаа өмнө гурван зарцаа дуудаж, эд хөрөнгөө даатгаад ингэж хэлэв. "Би өөрийнхөө бүх эд хөрөнгөө та нарт даатгаж өгөх тул намайг буцаж ирэх хүртэл энэ мөнгөөр наймаа хийцгээгээрэй." гэж хэлэв. Тэрээр нэг зарцдаа таван талант, хоёрдох зарцдаа хоёр талант, гуравдах зарцдаа нэг талантыг хувааж өгөв. Гэрийн эзэн холын аялалдаа гарсаны дараа таван талант болон хоёр талант авсан зарц нар нь даруй явж эзэнийхээ хэлсэнчилэн хичээнгүйлэн наймаа хийж эхлэв.

Хоёр зарц нь "бид хариуцсан ажлаа шаргуу хөдөлмөрлөж даван туулвал эзэн маань ихэд баярлах байхдаа" гэж бодогцоов. Таван талант авсан зарц нь хоёр дахин илүү олж арван таланттай болов.

Хоёр талант авсан зарц нь бас адилхан хоёр дахин илүү олж дөрвөн таланттай болсон байв.

Харин гуравдах зарц буюу нэг талант авсан зарц яасан бол?

Хэдэн сарын дараа эзэн нь урт хугацааны аялалаасаа буцаж ирэв.

Гурван зарц нар холоос ирсэн эзэн рүүгээ ирээд эзгүй байхад нь юу болсон талаар тайлагнав.

Гэрийн эзэн, эхний зарц болоод хоёрдах зарц нар нь даатгасан ажлыг хичээнгүйлэн хийсэн байгааг олж хараад маш их баяртай байв. Мөн хойшдоо ч олон зүйлийг хариуцуулан өгөх болно гэсэн амлалтыг тэдэнд өгөв.

Сүүлд нь гуравдах зарц нь ирж эзэндээ ингэж хэлэв.

"Эзэн, би таныг тариалаагүй газраас хадаж авдаг, цацаагүй газраасаа хураадаг хатуу хүн гэдгийг мэднэ.

Тэгээд наймаа хийж байгаад алдаа гаргаж миний толгой дээр хариуцлага буух вий гэхээс айгаад, үүнийхээ оронд таны өгсөн нэг талантыг газарт булчихсан юм. Энд таны надад өгсөн нэг талант байна.

Алга болгочхолгүй аваад ирлээ би." гэж хэлэв.

Үүнийг сонссон эзэн нь маш ихээр уурлав.

Эцэст нь өгөгдсөн авъяасаараа хичээнгүйлэн хөдөлмөрлөсөн зарц нар нь эзэнтэйгээ хамт аз жаргалтай цагийг өнгөрүүлж байв. Харин ямар ч оролдлого хийж үзээгүй залхуу зарц нь гүниглан уйлж байсан бөгөөд эзэн нь түүнийг гэрээсээ хөөв.



Бүтээлч байцгаая 1. Тоог бодож олоорой. Тэгвэл хариултыг олж чадна.

а. Гэрийн эзэн өөрийн хөрөнгийг хэдэн зарцдаа хувааж өгсөн бэ? $(5 + 2) - 4 =$ _____

б. Гэрийн эзэн нь зарц тус бүрдээ хэд хэдэн талант өгсөн бэ?

1. $1 + (10 \div 2) - 1 =$ _____

2. $2 - (20 \div 10) + 2 =$ _____

3. $1 \div 1 =$ _____

с. Зарц тус бүрдээ наймаа хийгээд нэмж хэдэн талант олсон бэ?

1. $150 \div 30 =$ _____

2. $240 \div 120 =$ _____

3. $10 - 10 =$ _____

● Доорх эшлэлийг уншаад цээжлээрэй. (Матай 25:21)

Эзэн нь түүнд “Сайн байна, сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор” гэжээ.

Бүтээлч байцгаая 2. Хоосон сагс болон ширээн дээр зарах боломжтой эд зүйлсүүдийг зураарай.
Зарц нарын хийсэн зүйлийг жишээ болгон авч бодож үзээрэй.

